



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/85/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитор П.Энхжаргал Цахим хаяг: Enkhjargalp@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	15
<b>3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>15</b>
3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

## 1.Аудитын санал дүгнэлт



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 144  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ТАРИАТ СУМЫН ЭМТ-ИЙН ДАРГА  
Т.ГЭРЭЛТУЯА ТАНАА

#### Аудитын санал дүгнэлт

##### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тариат сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тариат сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор нийт 11614.7 мянган төгрөгийн эм, боох материал санхүүгийн тайланд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.4, 73.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,532,821.34</b>	<b>240,947,753.03</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	68,402,106.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	68,402,106.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	68,402,106.00
31211	Төрийн сангийн харилцах	-	839,995.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	67,562,111.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	67,254,400.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	67,254,400.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	52,532,821.34	105,291,247.03
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	28,639,729.09	81,559,699.58
35130	Эм боох материал	28,639,729.09	81,559,699.58
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	23,893,092.25	23,731,547.45
35410	Бичиг хэргийн материал	951,156.00	954,800.00
35420	Аж ахуйн материал	19,769,869.90	18,205,495.90
35440	Түлш, шатах тослох материал	2,075,920.00	995,560.00
35450	Барилгын засварын материал	60,000.00	-
35460	Хүнсний материал	1,036,146.35	3,575,691.55
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,928,844,152.64</b>	<b>1,933,668,596.29</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,928,844,152.64	1,933,668,596.29
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,892,065,152.66	1,895,768,346.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,485,622,997.00	2,485,496,510.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(783,364,566.34)	(806,639,621.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	114,189,086.00	79,589,086.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,765,000.02)	(60,330,907.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	251,478,624.10	269,022,867.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(148,776,438.12)	(98,578,656.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	56,611,354.64	52,974,822.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,172,919.52)	(26,575,574.22)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,018,437.00	1,788,550.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,776,422.08)	(978,731.12)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	36,778,999.98	37,900,250.01
39301	Програм хангамж	250,000.00	1,450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(25,000.02)	(103,749.99)
39303	Бусад биет бус хөрөнгө	36,554,000.00	36,554,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,981,376,973.98</b>	<b>2,174,616,349.32</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,981,376,973.98</b>	<b>2,174,616,349.32</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,981,376,973.98	2,174,616,349.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	268,895,547.95	268,895,547.95
51101	Өмч: - төрийн	268,895,547.95	268,895,547.95
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	329,930,213.59	523,526,698.76
51210	Өмнөх үеийн үр дүн	319,198,458.24	319,555,568.07
51220	Тайлант үеийн үр дүн	10,731,755.35	203,971,130.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,382,551,212.44	1,382,194,102.61
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,981,376,973.98</b>	<b>2,174,616,349.32</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>848,949,792.15</b>	<b>1,548,951,854.16</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>121,617,774.15</b>	<b>436,863,054.16</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	121,617,774.15	436,863,054.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	121,617,774.15	436,863,054.16
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	839,995.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	88,588,086.00	80,636,924.56
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	33,029,688.15	355,386,134.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>727,332,018.00</b>	<b>1,112,088,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	681,746,500.00	670,262,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	681,746,500.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	670,262,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,458,900.00	380,185,700.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	373,900.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	312,871,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,000.00	60,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		67,254,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	39,464,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	39,464,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	44,126,618.00	22,176,400.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	44,126,618.00	22,176,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>829,865,036.80</b>	<b>1,320,974,101.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>829,865,036.80</b>	<b>1,320,974,101.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	829,125,036.80	1,272,974,101.25
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	520,772,185.00	604,186,600.00
210101	Үндсэн цалин	298,760,485.00	286,550,467.00
210102	Нэмэгдэл	168,441,300.00	190,264,709.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,547,000.00	-
210104	Урамшуулал	45,023,400.00	127,371,424.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,466,774.10	77,158,210.00
210201	Тэтгэврийн даатгал	44,394,917.10	54,296,545.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,221,700.00	5,715,441.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,160,626.00	4,572,233.00
210204	Ажилгүйдлийн даатгал	971,282.00	1,143,108.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,718,249.00	11,430,883.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,073,121.00	40,719,240.00
210301	Гэрэл, цахилгаан	2,526,900.00	3,999,950.00
210302	Түлш, халаалт	33,359,221.00	32,515,240.00
210303	Цэвэр, бохир ус	187,000.00	804,050.00
210304	Байрны түрээс	-	3,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,755,456.00	36,093,155.00
210401	Бичиг хэрэг	3,400,284.00	4,229,606.00
210402	Тээвэр, шатахуун	14,677,126.18	20,515,425.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	516,000.00	1,728,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	895,246.00	1,438,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,266,799.82	8,180,724.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	85,467,500.69	447,701,642.91
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	72,531,410.69	426,615,438.11

**Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	12,936,090.00	21,086,204.80
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,460,800.00</b>	<b>4,411,500.00</b>
210604	Урсгал засвар	2,460,800.00	4,411,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,491,900.00</b>	<b>574,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,491,900.00	574,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,793,950.00</b>	<b>1,133,950.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	770,000.00	208,950.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	95,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,450.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,589,200.00	-
210807	Газрын төлбөр	146,300.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	750,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>87,843,350.01</b>	<b>60,995,103.34</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,014,860.00	4,040,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	86,828,490.01	56,955,103.34
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>740,000.00</b>	<b>48,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>740,000.00</b>	<b>48,000,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	48,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	740,000.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>19,084,755.35</b>	<b>227,977,752.91</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>8,353,000.00</b>	<b>34,738,377.57</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,353,000.00	34,738,377.57
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(8,353,000.00)</b>	<b>(34,738,377.57)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,731,755.35</b>	<b>193,239,375.34</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	268,895,547.95	1,382,593,644.44	319,156,026.24	1,970,645,218.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	42,432.00	42,432.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>268,895,547.95</b>	<b>1,382,593,644.44</b>	<b>319,198,458.24</b>	1,970,687,650.63
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(42,432.00)	-	(42,432.00)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	10,731,755.35	10,731,755.35
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>268,895,547.95</b>	<b>1,382,551,212.44</b>	<b>329,930,213.59</b>	1,981,376,973.98
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>268,895,547.95</b>	<b>1,382,551,212.44</b>	<b>329,930,213.59</b>	1,981,376,973.98
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	357,109.83	357,109.83
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>268,895,547.95</b>	<b>1,382,551,212.44</b>	<b>330,287,323.42</b>	1,981,734,083.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(357,109.83)	-	(357,109.83)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	193,239,375.40	193,239,375.40
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>268,895,547.95</b>	<b>1,382,194,102.61</b>	<b>523,526,698.82</b>	2,174,616,349.38

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>727,332,018.00</b>	<b>1,045,674,395.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>839,995.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	839,995.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	-	839,995.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	839,995.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>727,332,018.00</b>	<b>1,044,834,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	681,746,500.00	670,262,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	681,746,500.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	670,262,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,458,900.00	312,931,300.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	373,900.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	312,871,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,000.00	60,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	39,464,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	39,464,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	44,126,618.00	22,176,400.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	44,126,618.00	22,176,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>721,627,118.00</b>	<b>961,391,289.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>721,627,118.00</b>	<b>961,391,289.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>720,887,118.00</b>	<b>913,391,289.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	520,772,185.00	604,186,600.00
210101	Үндсэн цалин	298,760,485.00	300,156,000.00
210102	Нэмэгдэл	168,441,300.00	189,973,547.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,547,000.00	-
210104	Урамшуулал	45,023,400.00	114,057,053.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	64,302,880.00	77,158,210.00
210201	Тэтгэврийн даатгал	44,231,123.00	54,296,545.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,221,700.00	5,715,441.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,160,626.00	4,572,233.00
210204	Ажилгүйдлийн даатгал	971,282.00	1,143,108.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,718,149.00	11,430,883.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,315,948.00	41,364,300.00
210301	Гэрэл, цахилгаан	2,526,900.00	3,999,950.00
210302	Түлш, халаалт	32,602,048.00	33,160,300.00
210303	Цэвэр, бохир ус	187,000.00	804,050.00

Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210304	Байрны түрээс	-	3,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,694,555.00	30,218,505.00
210401	Бичиг хэрэг	2,164,800.00	4,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,044,356.00	18,790,005.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	516,000.00	1,728,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	821,200.00	1,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,148,199.00	4,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	65,534,400.00	149,649,524.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,500,000.00	124,043,774.00
210502	Хоол, хүнс	13,054,400.00	23,625,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,980,000.00	1,980,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,481,300.00	4,148,000.00
210604	Урсгал засвар	2,481,300.00	4,148,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,491,900.00	574,700.00
210702	Дотоод албан томилолт	1,491,900.00	574,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,293,950.00	1,133,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	770,000.00	208,950.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	95,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	38,450.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,589,200.00	-
210807	Газрын төлбөр	146,300.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,500,000.00	750,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,000,000.00	4,957,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	4,957,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>740,000.00</b>	<b>48,000,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	740,000.00	48,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	48,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	740,000.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>5,704,900.00</b>	<b>84,283,106.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>5,704,900.00</b>	<b>15,881,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,704,900.00</b>	<b>15,881,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	5,704,900.00	15,881,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,704,900.00	15,881,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(5,704,900.00)</b>	<b>(15,881,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	68,402,106.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	68,402,106.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	762475700.00	731063105.00	31412595.00	95.9
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	762475700.00	731063105.00	31412595.00	95.9
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	762475700.00	731063105.00	31412595.00	95.9
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	532888000.00	532048005.00	839995.00	99.8
210101	Үндсэн цалин	300156000.00	299316005.00	839995.00	99.7
210102	Нэмэгдэл	176988000.00	176988000.00	0.00	100.0
210104	Урамшуулал	55744000.00	55744000.00	0.00	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71939900.00	71939900.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	50624400.00	50624400.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5328900.00	5328900.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4263000.00	4263000.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1065800.00	1065800.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	10657800.00	10657800.00	0.00	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	37964300.00	37964300.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4355000.00	3999950.00	355050.00	91.8
210302	Түлш, халаалт	33160300.00	33160300.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	449000.00	804050.00	-355050.00	179.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28928500.00	24885852.00	4042648.00	86.0
210401	Бичиг хэрэг	4200000.00	4200000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	17500000.00	13457352.00	4042648.00	76.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,728,500.00	1,728,500.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	66,667,500.00	40,203,598.00	26463902.00	60.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	49,000,000.00	27,223,548.00	21776452.00	55.6
210502	Хоол, хүнс	15,687,500.00	11,000,050.00	4687450.00	70.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,980,000.00	1,980,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,381,000.00	17,381,000.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,881,000.00	15,881,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	549,000.00	549,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	549,000.00	549,000.00	0.00	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,200,000.00	1,133,950.00	66050.00	94.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	208,950.00	41050.00	83.6
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	80,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	95,000.00	25000.00	79.2

Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	750,000.00	750,000.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,957,500.00	4,957,500.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,957,500.00	4,957,500.00	0.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	762,475,700.00	731,903,100.00	30572600.00	96.0
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	670,262,400.00	670,262,400.00	0.00	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	670,262,400.00	670,262,400.00	0.00	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	39,464,300.00	39,464,300.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	39,464,300.00	39,464,300.00	0.00	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	52,749,000.00	22,176,400.00	30572600.00	42.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	52,749,000.00	22,176,400.00	30572600.00	42.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	35	35.00		100.0
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32		100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2		100.0

## 2.5 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>245,369,189.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>245,369,189.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	197,369,189.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	71,298,600.00
210102	Нэмэгдэл	12,985,547.00
210104	Урамшуулал	58,313,053.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,218,310.00
210201	Тэтгэврийн даатгал	3,672,145.00
210202	Тэтгэмжийн даатгал	386,541.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	309,233.00
210204	Ажилгүйдлийн даатгал	77,308.00
210205	Эрүүл мэндийн даатгал	773,083.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3,400,000.00
210304	Байрны түрээс	3,400,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,332,653.00
210402	Тээвэр, шатахуун	5,332,653.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	109,445,926.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	96,820,226.00
210502	Хоол, хүнс	12,625,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,648,000.00
210604	Урсгал засвар	2,648,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	25,700.00
210702	Дотоод албан томилолт	25,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	48,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	48,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	48,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	312,931,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	312,931,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	312,871,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	60,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,562,111.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Тариат сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тариат сумын Эрүүл мэндийн төв нь нийгмийн болон эмнэлгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд “Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ээлтэй орчинд жигд, хүртээмжтэй, түргэн шуурхай, чанартай үзүүлж эрүүл амьдралын хэв маягийг сурталчилах ажлыг, өргөжүүлсэн анхны шатны эмнэлэг болно” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-иар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өөрчлөгдсөн
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 67/А/268 дугаар тушаал “Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай”
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/585 дугаар тушаал “Мөнгөн тэтгэмж олгох тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тариат сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэль сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр бэлтгэж, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 762.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 193.3 сая төгрөгөөр өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материалын дансдуудтай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	0	68.4	68.4	
Авлага	0	67.3	67.3	
Бараа материал	52.5	105.3	52.8	100.6
Үндсэн хөрөнгө	1928.8	1933.6	4.8	0.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1981.3</b>	<b>2174.6</b>	<b>193.3</b>	<b>9.8</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1981.3	2174.6	193.3	9.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1981.3</b>	<b>2174.6</b>	<b>193.3</b>	<b>9.8</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант онд 68.4 сая төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлдэг болсонтой холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл тайлант онд 67.3 сая төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах ковидын цогц тусламж үйлчилгээний санхүүжилт нэхэмжилснээс дутуу ирсэнтэй холбоотой байна.
- Бараа материал эхний үлдэгдлээс 100.6 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 52.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 184.7 сая төгрөг, хандиваар 355.4 сая төгрөг нийт 540.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 487.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 105.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс эм боох материалын үлдэгдэл 81.6 сая төгрөг байна.

- Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 0.2 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,928.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 15.9 сая төгрөг, хандиваар 80.6 сая төгрөг нийт 96.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 56.9 сая төгрөгийн, элэгдүүлж дуусаагүй үндсэн хөрөнгө акталсантай холбоотойгоор 34.8 сая төгрөгийн зардал гарч, 1,933.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 193.3 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 954.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 192.1 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 762.5 сая төгрөгөөр хянаж баталсан бол тодотголоор батлагдсан төсөвт өөрчлөлт ороогүй байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 762.5 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 30.6 сая төгрөгийн санхүүжилт Эрүүл мэндийн даатгалын сангаас дутуу ирсэн байна. Тайлант онд үндсэн санхүүжилтээс 731.1 сая төгрөгийг, нэмэлт санхүүжилтээр 245.4 сая төгрөгийг зарцуулж, 68.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМДС-аас ковид-19-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээний санхүүжилт 234.2 сая төгрөг, дархлаажуулалтын вакцинд

зориулан 30.6 сая төгрөг, Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг урамшуулах зорилгоор олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 48.0 сая төгрөг, нийт 312.8 сая төгрөг ирсэн байна. Ирсэн санхүүжилтийг зарцуулах эрхийн хүсэлт нээлгэн зарцуулсан байна. Үүнд: цалин шимтгэлд 76.6 сая, байрны түрээсийн зардалд 3.4 сая, тээвэр шатахуунд 5.3 сая, эмийн зардалд 96.8 сая, хоол хүнсэнд 12.6 сая, урсгал засварын зардалд 2.6 сая, мөнгөн тэтгэмжид 48.0 сая, албан томилолтын зардалд 0.003 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тариат сумын Эрүүл мэндийн төв нь тайлант жилд ковид-19 халдварын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээг нийт 451 хүнд үзүүлж ЭМДС-аас 382.5 сая төгрөгийн санхүүжилт нэхэмжилж гүйцэтгэлээр 234.2 сая төгрөг авч, даатгалаас хянагдаад буцаагдсан 81.1 сая төгрөг хасагдаад оны эцэст 67.2 сая төгрөгийн авлагатай тайлагнасан.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлж 68.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй үлдэгдлээр тайлагнасан бол ЭМГ-ын даргын 2021.08.25-ны өдрийн 02/849 дугаар тушаалын дагуу 81.6 сая төгрөгийн эмийн нөөцийг бүрдүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын А/496, А/585 дугаар тушаалын дагуу коронавируст халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 48.0 сая төгрөг олгосон байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 11 үндсэн зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 762.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 95.9 хувийн биелэлттэй байна.

Тариат сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны А/12 дугаар тушаалаар 2021 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комиссыг томилсон байна. Тооллогын комиссын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн тооллогод 331 төрлийн 81.1 сая төгрөгийн эм тоологдож 67 нэр төрлийн 11.7 сая төгрөгийн эм дутагдсан, 72 нэр төрлийн 4.6 сая төгрөгийн эм боох материал илүүдсэн байна. Аудитаар эмийн орлогыг тулгахад Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/125 дугаар тушаалаар нийт 4.5 сая төгрөгийн фавипиравир эм олгосныг орлогод аваагүй байна. Тус байгууллагын удирдлага нь тооллогын дүнг баталгаажуулах, тооллогоор илэрсэн зөрчлийг шийдвэрлэх, нягтлан бодох бүртгэлд тусгах зэрэг хуульд заасан арга хэмжээг аваагүй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4, 73.1.3, 73.1.4, 73.2 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тус байгууллага нь тайлант онд 355.4 сая төгрөгийн бараа материал, 80.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хандив тусламжаар авч тайланд бүрэн тусгасан байна.
- Үндсэн орон тооны жолоочтой бөгөөд цалингийн зардалд 13.9 сая төгрөг олгосон байна. Тайлант онд 79.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 УАЗ-пургон авто машин бүртгэлтэй бөгөөд шатахууны зардалд 20.5 сая төгрөг зарцуулсан байна. Харин өмнө нь ашиглагдаж байсан 34.6 сая төгрөгийн балансын үнэтэй

УАЗ Фургон авто машиныг аймгийн ИТХ-ын 2021.04.16-ны өдрийн 13 дугаар тогтоолын дагуу аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн байна.

Харин бусад судалгаанд хамаарах мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тариат сумын Эрүүл мэндийн төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 180 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Харин өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 13 тушаалаар 319.9 сая төгрөгийн шийдвэрийг бүрэн байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Эрүүл мэндийн төв нь Ковидын тухай хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа тул Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалт хамааралгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт хамааралгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд дотоод хяналт болон элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн үндсэн хөрөнгөтэй холбоотой 2 заалт зөвлөмж өгч биелэлтийг бүрэн хангуулсан.

#### **3.10 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Нэмэлт санхүүжилт, хандив тусламжийн зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 11.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Залруулагдаагүй 1 алдаа, зөрчлийн дүн 11.7 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 7.8 сая төгрөгөөс хэтэрсэн тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

#### 4.1 Албан шаардлага

Тариат сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2021.12.03-ны өдрийн А/12 тоот тушаалын дагуу 2021 оны жилийн эцсийн эмийн тооллого явуулахад 331 нэр төрлийн 81,082.3 мянган төгрөгийн эм тоологдсноос 67 нэр төрлийн 11,730.4 мянган төгрөгийн эм боох материал дутагдаж, 72 нэр төрлийн 4,603.7 мянган төгрөгийн эм боох материал илүүдсэн байна. Мөн аудитын явцад Эрүүл мэндийн газрын даргын 2021.06.25-ны өдрийн А/125 тоот тушаалаар нийт 4,488.0 мянган төгрөгийн фавипиравир нийлүүлэгдснийг хүлээн аваагүйгээс нийт 11,614.7 мянган төгрөгийн эм боох материал дутагдуулсан байхад түүнийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээг авч, санхүүгийн тайланд тусгаагүй, эм боох материалын эцсийн үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.3-д “Эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед”, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 7-д “Эд хариуцагч нь энэ дүрмийн шаардлагыг зөрчих, хариуцсан өмч хөрөнгийг гэмтээж чанар алдагдуулах, тооцоог будилаантуулах, идэж ашиглах үрэгдүүлсэн явдал илэрвэл хууль зүйн дагуу хариуцлага хүлээж, гарсан хохирлыг учирсан хохирлоор шууд тооцож, тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцон нөхөн төлж барагдуулна” Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд санхүүгийн тайланд тусгасан эм боох материалын дүн нь тооллогын дүнгээс зөрүүтэй тооллогын дүн эргэлзээтэй байх тул тооллогыг дахин явуулж эцсийн дүнг гаргаж 2022.03.15-ний өдрийн холбогдох материалыг ирүүлж дахин шалгуулах албан шаардлагыг хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитын асуудал										
	Тариат сумын ЭМТ	1	11.6					1	11.6		
	дүн	1	11.6					1	11.6		
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
	Тариат сумын ЭМТ	1	0	0	0	0	0	0	0	1	0
	дүн	1	0							1	0
	<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>11.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>